

Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт

Чанар, Хариуцлагатай
байдлын Хүмүүнлэгийн Үндсэн
Стандарт

Хэвлүүлэн гаргасан: CHS Холбоо, Сфер төсөл, Groupe URD

Чанар, Хариуцлагатай байдлын Хүмүүнлэгийн Үндсэн Стандартын (CHS) нь Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр 2017 онд орчуулагдан хэвлэгдэв.
This publication was independently translated by World Vision International Mongolia in 2017



Эхний хэвлэл: 2014 он

ISBN: 978-2-8399-1504-9

© Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Энд багтсан материалын зохиогчийн эрхийг CHS Холбоо, Сфер төсөл болон Groupe URD нар эзэмшдэг. CHS-ын удирдамж заавар, шалгуур үзүүлэлтүүд гэж дурьдах замаар энэхүү материалыг сургалт, судалгаа, хөтөлбөрийн үйл ажиллагаа гэх мэт боловсролын зорилгод хуулбарлах буюу олшруулан хэрэглэж болно. CHS-ын удирдамж заавар, шалгуур үзүүлэлтүүдийг бүхэлд нь буюу хэсэгчлэн орчуулах, эсвэл хялбаршуулан өөрчлөх бол info@corehumanitarianstandard.org хаягаар цахим шуудан илгээж, урьдчилан бичгээр үйлдсэн зөвшөөрөл авах ёстой.

ӨМНӨХ ҮГ

Чанар, хариуцлагатай байдлын Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт(CHS) нь хэрэглэгчдэд зориулж стандартуудын жигд, нийцтэй байдлыг хангах зорилгоор NAR International, People in Aid болон Sphere Project нарын хамтран ажилласан Нэгдсэн Стандарт гаргах хамтын санаачлагын (JSI) шууд үр дүн юм. JSI нь Нэгдсэн Стандарт гаргах хамтын санаачлагын хүрээнд төв, бүс нутгууд болон гамшигт өртөмтгий улс орнуудад ажиллаж буй 2000 гаруй хүмүүнлэгийн ажилчидтай зөвлөлдсөн билээ. Энэхүү зөвлөгөөнөөс гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийн үйл ажиллагааны төвд тавьсан, хүмүүнлэгийн зарчмуудад суурилсан стандартуудын жигд нийцтэй байдлыг хангасан, нэгдсэн стандарттай болох хэрэгцээ шаардлага байгаад ихээхэн ач холбогдолтой санал зөвлөмж гарсан.

CHS нь 3 үе шаттайгаар 12 сарын хугацаанд явагдсан зөвлөлдөөний үр дүн бөгөөд энэ хугацаанд хүмүүнлэгийн ажилтнууд, гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс, хэдэн зуун төрийн бус байгууллагууд (ТББ), тэдгээрийн сүлжээ салбарууд, орон орны засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага болон хандивлагч байгууллагууд, мөн дээд шатны боловсролын байгууллагууд CHS-ын агуулгад нарийн дүн шинжилгээ хийж, CHS-ын төвд болон гамшигийн талбарт туршиж үзсэн.

Зөвлөлдөөн нэг бүрээс гарсан санал зөвлөгөөг хүмүүнлэгийн арга хэмжээ, стандартыг боловсруулах техникийн нарийн мэргэшлийн төрөл бүрийн салбарын төлөөлөл болсон 65 гишүүнтэй Техникийн зөвлөх групп хэлэлцэж, засвар өөрчлөлт оруулан баталсан.

NAR International, People in Aid болон Sphere Project гурван байгууллагын төлөөлсөн удирдах зөвлөл 2010 онд NAR International байгууллагаас гаргасан Хариуцлагатай байдал болон чанарын менежмент, People in Aid байгууллагаас гаргасан Тусламжийн боловсон хүчний менежмент болон дэмжлэгийн зохистой практик, мөн Sphere байгууллагаас гаргасан Сфер гарын авлагын Үндсэн Стандарт нэртэй хэсгийг тус тус CHS-аар орлуулахыг зорьж байгаа болно.

ТАЛАРХАЛ

CHS-ын төсөл хувилбарт санал зөвлөгөө өгөх, CHS-ыг байгууллагадаа турших¹, мөн CHS-ын зөвлөлдөөний үйл явцад хяналт тавих ажлын хэсэгт оролцох зэргээр CHS-ыг боловсруулан гаргахад хувь нэмрээ оруулсан хэдэн зуун байгууллагууд, хувь хүмүүст ялангуяа гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийг зөвлөлдөөний болон туршилтын үйл явцад өргөнөөр хамрагдсан хүмүүст талархал илэрхийлье.

Стандартуудын жигд, нийцтэй байдлыг хангахад чиглэсэн NAP International, People in Aid байгууллагууд болон Sphere Project хүчин чармайлтад Groupe URD нэгдэн, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааны чанарын баталгааг хангах Quality COMPAS лавлагаа баримт бичгийг CHS-д нэгтгэн оруулсан болно. CHS-ын Техникийн зөвлөх групп болон түүний харьяа техникийн удирдлагын хороо нь CHS-ын зөвлөлдөөний үйл явцыг удирдан хянах, CHS-ыг эцэслэн батлах үүрэгтэй байсан бол CHS-ын Бичих групп нь зөвлөлдөөний үе шат бүрээс ирүүлсэн санал зөвлөгөөг CHS-д тусгаж, өөрчлөлт оруулах үүргийг хүлээж ажиллалаа.

Үүнээс гарах үр дүн нь нийтэд нь хамруулан төлөөлсөн, бодитой байх явдлыг хангах үүднээс CHS-ын зөвлөлдөөнийг WolfGroup-ийн зөвлөхүүд хараат бус байдлаар зохион байгууллаа.

Техникийн зөвлөх групп, Техникийн удирдлагын хороо болон Бичих группын гишүүдийн жагсаалтыг www.corehumanitarianstandard.org хаягаар орж үзэж болно. Энэ хүмүүсийн тууштай дэмжлэггүйгээр CHS-ын зөвлөлдөөнийг төсөөлөх боломжгүй юм.

Хүмүүнлэгийн Үндсэн Стандартыг боловсруулан гаргах үйл явцын болон төслийн санхүүжилтийг Австралын Гадаад хэрэг, худалдааны яам, Хилийн чанад дахь хөгжлийн төлөө католик шашинтнуудын байгууллага (CAFOD), Дани улсын Гадаад хэргийн яам (Данида), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Гадаад алба, Ирландын тусламжийн байгууллага (Irish Aid), Швед улсын Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага, Швейцарь улсын Хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Их Британийн засгийн газрын харьяа Их Британийн тусламж (UK Aid), Америкийн Нэгдсэн Улсын засгийн зэрэг хандивлагч орнууд хангаж ажиллалаа.

NAP International, People in Aid болон Sphere Project байгууллагуудын зүгээс төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байгууллагуудад CHS-ыг боловсруулахад санхүүгийн талаас хувь нэрмээ оруулсан явдалд талархал илэрхийлж байна. Эдгээр байгууллагуудын тоонд ACT Alliance, ActionAid International, Aktion Deutschland Hilft, Их Британийн Улаан загалмайн нийгэмлэг, Хилийн чанад дахь хөгжлийн төлөө католик шашинтнуудын байгууллага (CAFOD), CARE International, Christian Aid, Community World Service Asia, DanChurchAid, The Lutheran World Federation, Хүүхдийг ивээх сан Олон Улсын Байгууллага, АНУ-ын Хүүхдийг ивээх сан, Дэлхийн Зөн Олон улсын байгууллага (WVI) орно.

¹ CHS-ыг туршсан байгууллагуудын бүтэн жагсаалтыг www.corehumanitarianstandard.org хаягаар орж үзэж болно.

САНАЛ ЗӨВЛӨГӨӨ

CHS-тай холбогдуулан өгөх санал зөвлөгөө болон асуултаа info@corehumanitarianstandard.org хаягаар илгээнэ үү.

ДАХИН ХЯНАН ҮЗЭХ

Хүлээн авсан бүх санал сэтгэгдлийг CHS-д өөрчлөлт оруулах ажлын үеэр авч хэлэлцэнэ. CHS-д өөрчлөлт оруулах ажил 2019 оны 12 сард багтаан хийгдэж дуусна. Та бүхэн www.corehumanitarianstandard.org хаягаар орж, Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт, түүнтэй холбоотой материалууд болон боловсруулалтын шатанд яваа бусад баримт бичгийн талаар илүү их мэдээлэл авч болно.

СТАНДАРТЫГ ОРЧУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨ МЖ

Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт нь араб, франц, испани хэл дээр орчуулагдсан болно. CHS-ыг өөр хэл рүү хөрвүүлж орчуулахыг хүсвэл info@corehumanitarianstandard.org хаягаар холбогдож, орчуулгыг гүйцэтгэх удирдамж зааварчилгааг авна уу. CHS-ын орчуулгыг www.corehumanitarianstandard.org хаягаар орж үзэх боломжтой.

ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД

CHS-ыг практикт хэрэглэх удирдамж болон арга хэрэгслүүдийг боловсруулан гаргасан бөгөөд www.corehumanitarianstandard.org хаягаар орж, эдгээр материалтай чөлөөтэй танилцаж болно.

ГАРЧИГ

I.	Оршил	8
II.	Чанар, хариуцлагатай байдлын тухай Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (CHS)-ын бүтэц	10
III.	CHS-г хэрэгжүүлэх тухай	11
IV.	CHS-ыг мөрдөж ажилладаг эсэхийг мэдээлэх нөхцөл	12
V.	Хүмүүнлэгийн зарчимч үйл ажиллагаа	13
VI.	Есөн Амлалт ба Чанарын шалгуур үзүүлэлт	14
VII.	Амлалт, үйл ажиллагаа, хүлээх үүрэг хариуцлага	15
1.	Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс хэрэгцээндээ тохирсон бөгөөд холбогдолтой тусламжийг хүлээн авна.	15
2.	Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс хэрэгцээт хүмүүнлэгийн тусламжийг зөв зохистой цагтаа хүртэнэ.	16
3.	Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үр дүн нь гамшигт өртсөн орон нутаг, хүмүүсийг бэлэн байдлаа илүү хангасан, эрсдэлд бага өртөх, даван туулах чадвартай байхад чиглэх ба сөрөг үр нөлөөгүй байна	17
4.	Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс эрхээ мэддэг, мэдээлэл авах боломжтой, өөрсөддөө нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргахад оролцоотой байна.	18
5.	Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс, санал хүсэлт гаргах, шийдвэрлэх, хянах аюулгүй бөгөөд шуурхай механизмаар хангагдсан байна.	19
6.	Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс зохион байгуулалттай, харилцан бие биенээ нөхсөн хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авна.	20
7.	Байгууллагууд туршлага, эргэцүүлээсээ суралцах тусам тусламжийн үйл ажиллагаа улам сайжирна гэж гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс итгэж болно.	21
8.	Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс шаардлагатай тусламжийг чадвартай, удирдлага, зохион байгуулалт сайтай ажилтнууд болон сайн дурынхнаар дамжуулан хүлээн авна.	22
9.	Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүст тусламж үзүүлж буй байгууллагууд нөөцийг үр дүнтэй, үр ашигтай, ёс зүйтэй удирдан зохицуулж байгаа гэдэгт итгэж найдаж болно.	23
VIII	Нэр томъёоны тайлбар	24

Чанар, Хариуцлагатай байдлын Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт

I. ОРШИЛ

Өдгөө дэлхийн өнцөг булан бүрт, хүмүүсийн амьдралын бүхий түвшинд маш олон хүмүүс хүмүүнлэгийн үүрэг хариуцлагын хүрээнд хүмүүсийг аливаа гай зовлонд өртөхөөс урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд учирсан хохиролыг багасгахад хариу арга хэмжээ авахад туслалцаа үзүүлж байна.

Чанар, хариуцлагатай байдлын тухай Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (CHS)-д хүмүүнлэгийн хариу үйл ажиллагаанд оролцож буй байгууллагууд болон хувь хүмүүс өөрийн үзүүлж буй тусламжийн чанар, үр дүнг сайжруулах зорилгоор хэрэглэж болох Есөн амлалтыг тусгажээ. Мөн уг Стандарт нь хүмүүнлэгийн байгууллагуудыг гамшигт өртсөн орон нутаг болон хувь хүмүүсийн өмнө илүү хариуцлагатай ажиллахад чиглүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл хүмүүнлэгийн байгууллагуудын хүлээсэн үүргийг гамшигт өртсөн орон нутаг болон хувь хүмүүс мэдэж авснаар тухайн байгууллагуудыг хариуцлагатай байлгах боломжийг тэдэнд нээж өгсөн байна.

CHS нь гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийг хүмүүнлэгийн үйл ажиллагааны төвд тавьж байгаа бөгөөд тэдний язгуур эрхийг хүндлэх үзэл санааг дэмжжээ. Стандарт нь Хүний эрхийн тухай олон улсын хууль¹ гэх мэт олон улсын эрхзүйд тусгасан хүний нэр төртэй амьдрах эрх болон хамгаалуулах эрхэд үндэслэсэн.

Үндсэн Стандарт болохын хувьд CHS нь зарчимч, хариуцлагатай, өндөр чанартай хүмүүнлэгийн үйл ажиллагааны үндсэн элементүүдийг тодорхойлж өгсөн. Хүмүүнлэгийн байгууллагууд өөрийн дотоод журмуудыг нийцүүлэх сайн дурын хууль болгон энэхүү стандартыг хэрэглэж болно. Мөн ажлын гүйцэтгэлийг шалгах үндэс суурь болгон уг стандартыг хэрэглэж болох бөгөөд энэ зорилгыг хангах үүднээс төрөл бүрийн байгууллага, орчин нөхцөлд тохируулахын тулд хамрах тодорхой хүрээ болон холбогдох үзүүлэлтүүдийг боловсруулсан болно.

CHS-ыг хүмүүнлэгийн арга хэмжээ авч байгаа болон хүмүүнлэгийн арга хэмжээнд хувь нэмрээ оруулж байгаа хувь хүмүүс, байгууллагууд, зохицуулах байгууллагууд, консорциумууд болон бусад бүлгүүд дэмжин сурталчилж, хэрэгжүүлж болно. Хэдийгээр хүмүүнлэгийн салбарт түлхүү зориулагдсан ч, үйл ажиллагаагаа бүх талаар чанаржуулж, илүү хариуцлагатай болгох үүднээс гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүстэй ажиллаж буй аль ч байгууллага CHS-ыг хэрэглэж болно.

¹ Хүний эрхийн тухай олон улсын хуулинд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон түүний нэмэлт протоколууд багтана.

CHS нь дэлхийн хэмжээнд зохион байгуулагдсан зөвлөлдөөний үр дүн юм. Энэхүү стандартад одоо хэрэгжиж байгаа хүмүүнлэгийн стандартууд болон үүрэг амлалтуудыг агуулсан баримт бичгүүдийн үндсэн элементүүдийг нэгтгэн оруулсан. Эдгээрт доор дурьдсан стандарт, баримт бичгүүд орсон боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган сар хөдөлгөөн болон гамшгийн яаралтай тусламж, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр ажилладаг ТББ-уудын Ёсзүйн хэм хэмжээ;
- НАР (Хүмүүнлэгийн Хариуцлагатай Байдлын Хөтөлбөр)-ын гаргасан Хариуцлагатай байдал, чанарын менежментийн тухай 2010 оны стандарт;
- The People in Aid-ийн гаргасан Тусламжийн боловсон хүчний менежмент, дэмжлэгийн зохистой практикийн сайн туршлагууд;
- Сферийн гарын авлага: Үндсэн стандартууд болон Хүмүүнлэгийн тунхаглал;
- Хүмүүнлэгийн тусламжийн чанарын баталгааны баримт бичиг The Quality COMPAS;
- Гамшгийн нөлөөнд өртсөн хүмүүс/хүн амын өмнө хүлээх хариуцлагатай байдлын тухай Байгууллага Хоорондын Байнгын Хорооны амлалт;
- Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-ын Хөгжлийн туслалцааны хороо (ХТХ)-ны Хөгжлийг болон хүмүүнлэгийн тусламжийг үнэлэх шалгуур үзүүлэлт.

Чанар, хариуцлагатай байдлын Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт



II. ХҮМҮҮНЛЭГИЙН ҮНДСЭН СТАНДАРТЫН БҮТЭЦ

CHS нь гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүст хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх хувь хүн болон байгууллагуудын хүлээх 9 үүрэг болон амлалтын цогц юм. Амлалт нэг бүрт хүмүүнлэгийн байгууллагууд болон ажилтнуудын ажиллах стандартын индикаторыг харуулсан Чанарын шалгуур үзүүлэлт дагалдсан. CHS нь дараах бүтэцтэй. Үүнд:

- Есөн амлалт;
- Дагалдах Чанарын шалгуур үзүүлэлтүүд;
- Амлалтыг биелүүлэхийн тулд хийж гүйцэтгэх Үндсэн үйл ажиллагаа;
- Байгууллагын хэмжээнд Үндсэн үйл ажиллагааг тууштай бөгөөд системтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн Байгууллагын хүлээх үүрэг.

Үндсэн үйл ажиллагаа болон Байгууллагын хүлээх үүрэгт дараах зүйлсийг тусгажээ. Үүнд:

- Хөтөлбөрийг чанарын өндөр түвшинд хүргэх, мөн тусламж үзүүлэхээр зорьж буй хүмүүсийн өмнө хариуцлагатай байдлыг хангахын тулд хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцож буй ажилтнуудын хийвэл зохих зүйлс;
- Чанартай, хариуцлагатай хүмүүнлэгийн тусламж үзүүлэх явдлыг хангаж ажиллахын тулд хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад байвал зохих ажилтанууддаа зориулсан бодлого, процесс, системүүд.

Энэ баримт бичгийн төгсгөлд CHS-д хэрэглэсэн нэр томъёоны тайлбарыг тусгай тодорхойлолтын хамтаар оруулсан болно.

III. CHS-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

CHS-ын өмнө үүрэг хүлээсэн байгууллагууд Есөн амлалтыг бүгдийг нь хэрэгжүүлэхийг зорино. Хамгийн багадаа тэд өөрсдийн хэрэгжүүлж буй хүмүүнлэгийн хариу арга хэмжээний чанар, хариуцлагыг тууштай сайжруулах үүднээс байгууллагынхаа тогтолцоо, бүтэц, практикийг тогтмол сайжруулах үүрэгтэй байна. Гэхдээ хүмүүнлэгийн арга хэмжээнд оролцож буй байгууллагууд болон хувь хүмүүс харилцан адилгүй. Тэд цаг алдалгүй ажиллаж, өөрсдийн үйл ажиллагааг байгууллагынхаа чадавх, эрх хэмжээг гамшигийн үе шат, нөхцөл байдалтай уялдуулах шаардлагатай.

Есөн амлалтыг биелүүлэхэд хүндрэл бэрхшээл тулгарсан үед байгууллагууд үүнийгээ хүлээн зөвшөөрч, саад тушаа болж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар авч үзэн дахин хүндрэлтэй нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй. Байгууллагууд үүнтэй төстэй нөхцөл байдлаас суралцаж, өөрт тулгарч буй саад тотгорыг даван туулах арга замыг боловсруулбал зохино.

CHS-ын хэрэглээнд дүн шинжилгээ хийхдээ зөвхөн Үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн эсэхийг болон/ буюу Байгууллагын хүлээх үүргийг биелүүлсэн эсэхийг үнэлэх үнэлгээнд бус харин Есөн амлалтыг хангахын төлөө ажиллаж буй түвшинд үндэслэн дүгнэнэ. Тиймээс CHS-д шаардсан Үндсэн үйл ажиллагааг тухайн нөхцөл байдалд тохируулан өөрчлөх хэрэгтэй.

CHS нь доор тодорхойлсон байгууллагууд болон хувь хүмүүст хамаарна. Үүнд:

- Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүст шууд тусламж үзүүлдэг;
- Тусламж үзүүлэхэд шууд оролцдоггүй боловч бусад тусламж үзүүлэгч байгууллагуудад санхүүгийн, материаллаг, эсвэл техникийн дэмжлэг үзүүлдэг;
- Дээрх хоёр аргыг хослуулсан

CHS нь хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцож буй байгууллагууд болон хувь хүмүүст доор дурдсан болон бусад хүмүүнлэгийн үйл ажиллагааны зорилгыг хангах арга хэрэгсэл болж, төрөл бүрийн арга хэлбэрээр ашиглагдах зориулалттай. Үүнд:

- Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлж, тэдэнд үзүүлж буй тусламж, үйлчилгээг чанаржуулах
- CHS-ыг дэвшилтэт хэлбэрээр хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах ажлын төлөвлөгөө боловсруулах;

- CHS-ыг байгууллагын болон техникийн стандартуудыг дагалдах үйл ажиллагааны хүрээ болгон дэмжих, сайжруулах үндсэн суурь болгон ашиглаж, чанар, хариуцлагатай байдлын хяналт хийх,
- Хөтөлбөрүүдийн чанарыг дотооддоо үнэлж, сайжруулах;
- Хэрэгжилтийг шалгах буюу баталгаажуулах, бусдад үлгэрлэн харуулах;
- Дотоод процесс болон ажилтнуудад үзүүлэх дэмжлэг нь CHS-д тусгасан үйл ажиллагаа болон байгууллагын хүлээх хариуцлагыг хэр зэрэг хангаж байгааг үнэлэх.

CHS-ыг ашиглахаар шийдсэн байгууллагууд CHS-ыг дан ганц байгууллагын дотооддоо төдийгүй байгууллагаас гадуур мөн хэрэгжүүлнэ.

Бусад байгууллагатай түншлэлийн хэлбэрээр хамтарч ажилладаг байгууллагууд тэдэнд CHS-ын өмнө хүлээсэн амлалт үүргийнхээ талаар тайлбарлан, хамтрагч байгууллагууд² нь Есөн амлалтыг хэрхэн авч үзэж байгааг ойлгохыг эрмэлзэж, CHS-ын амлалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор тэдэнтэй хамтран ажиллахын тулд дээд зэргийн хүчин чармайлт гаргана.

IV. CHS-ЫГ МӨРДӨЖ АЖИЛЛАДАГ ЭСЭХИЙГ МЭДЭЭЛЭХ НӨХЦӨЛ

Хүмүүнлэгийн арга хэмжээнд оролцож буй аливаа хувь хүн болон байгууллагад CHS-ыг ашиглахыг зөвлөнө. Ийм хувь хүн болон байгууллага нь “бид CHS-ыг хэрэглэхийг зорьж ажиллаж байгаа” хэмээн дурьдаж болно. Байгууллагууд зөвхөн бодитой баримт нотолгоотой тохиолдолд CHS-ыг мөрдөж ажилладаг хэмээн мэдээлж болно.

² Тодорхойлолтыг тайлбар хэсгээс харна уу.

V. ХҮМҮҮНЛЭГИЙН ЗАРЧИМЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүмүүнлэгийн арга хэмжээний цөм нь хүмүүс байна. Гамшгийн мөрөөр авах аливаа арга хэмжээний анхдагч сэдэл болон үүрэг нь хүний амь аврах, зовлон зүдгүүрийг арилгах, хүний нэр төртэй амьдрах эрхэд дэмжлэг үзүүлэх явдал байна.

Хүмүүнлэгийн байгууллагууд нь хүний хэрэгцээ, шаардлага нэн тэргүүнд тавигдана гэдгийг хүлээн зөвшөөрч, шаардлагатай газар бүрт хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийг эрмэлзэнэ.

Хүмүүнлэгийн арга хэмжээ нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дараах дөрвөн зарчмыг³ баримтлана. Үүнд:

- **Хүмүүнлэг энэрэнгүй байх зарчим:** Хүний зовлон шаналалыг багасгахад хаана ч бай газар нутаг үл харгалзан шийдвэрлэх ёстой. Хүмүүнлэгийн арга хэмжээ нь амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүнийг хүндлэх эрхэм зорилготой.
- **Шударга байх зарчим:** Хүмүүнлэгийн арга хэмжээг дан ганц хэрэгцээнд үндэслэн, зовлон шаналалын хамгийн яаралтай тохиолдлыг нэн тэргүүнд анхаарч, яс үндэс, арьс өнгө, хүйс, шашны итгэл үнэмшил, нийгмийн анги давхарга, улс төрийн үзэл баримтлалд үндэслэн сөрөг байдлаар ялган авч үзэхгүйгээр хэрэгжүүлнэ.
- **Хараат бус байх зарчим:** Хүмүүнлэгийн арга хэмжээ нь хүмүүнлэгийн арга хэмжээг хэрэгжүүлж буй газар нутагтай холбоотойгоор тулгарч болох улс төр, эдийн засаг, цэргийн болон бусад хоригоос ангид, хараат бус, бие даасан байна.
- **Төвийг сахисан байх зарчим:** Хүмүүнлэгийн байгууллагууд болон ажилтнууд дайны цагт аль нэг талд орохгүй, мөн улс төр, арьс өнгө, шашин, үзэл суртлын чанартай маргаанд оролцохгүй⁴.

Хүмүүнлэгийн зарчмууд нь хүмүүнлэгийн бүхий л үйл ажиллагааны үндэс суурь нь байна. Эдгээр зарчмууд нь хүмүүнлэгийн арга хэмжээний удирдлага болох бөгөөд зарчмуудыг хэрэглэх нь хүмүүнлэгийн арга хэмжээг бусад хэлбэрийн үйл ажиллагаа, арга хэмжээнээс ялгахад чухал үүрэгтэй байна. CHS-д дээрх дөрвөн зарчмыг Амлалт, Чанарын шалгуур үзүүлэлт, Үндсэн үйл ажиллагаа, Байгууллагын хүлээх үүрэгтэй уялдуулан оруулсан болно.

Олон улсын хүмүүнлэгийн хууль, Хүний эрхийн тухай олон улсын хууль, Дүрвэгсдийн тухай олон улсын хуульд хувь хүмүүс болон бүлгүүдийг хамгаалах, тэдэнд үзүүлэх тусламж үйлчилгээний мөн чанарт холбогдох эрх зүйн суурь стандартуудыг заасан байдаг. Гамшигт өртсөн болон аливаа тэмцэл, мөргөлдөөний нөлөөнд өртсөн хүмүүсийн сайн сайхан байдалд хамгийн их хамаарах эрх зүйн үндсэн зарчмуудыг Сфер Хүмүүнлэгийн тунхаглалд хураангуйлан тусгасан байдаг.

Хүмүүнлэгийн Үндсэн Стандартыг хэрэглэдэг байгууллага, хувь хүмүүс өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд гамшгийн аюулд өртсөн буюу эсвэл зэвсэгт мөргөлдөөний нөлөөнд өртсөн хүмүүсийг хамгаалах болон тэдэнд туслах үндсэн, анхдагч үүргийг тухайн газар нутагт орон нутгийн төр засаг болон холбогдох эрх бүхий бусад байгууллагууд хүлээдэг болохыг ойлгож, хүлээн зөвшөөрдөг. Иймээс хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь дээр дурьдсан байгууллагуудын хүлээсэн үүргийг сулруулах учиргүй бөгөөд боломжтой тохиолдолд тэдэнд нэмэлт дэмжлэг болох учиртай.

3 Хүмүүнлэг энэрэнгүй, шударга, хараат бус, төвийг сахисан байх тухай зарчмууд нь 1965 онд Вьенна хотноо болсон Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар нийгэмлэгүүдийн холбооны 20-р бага хурлаас тунхагласан Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Хөдөлгөөний үндсэн зарчмууд, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассемблейн 1991 оны 12 сарын 19-ний өдрийн 46/182 тоот тогтоол, НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2004 оны 2 сарын 5-ны өдрийн 58/114 тоот тогтоолоос гаралтай.

4 Алагчлан сэхэхгүй, шударгаар тусламж үзүүлэх, дайны цагт аль нэг талд орохгүй байх үүрэг хүлээсэн хэрнээ зарим байгууллагууд төвийг сахих тухай зарчим нь хариуцлага, шударга ёстой холбоотой асуудлаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулахыг хориглодоггүй гэж үздэг.

VI. ЕСӨН АМЛАЛТ БОЛОН ЧАНАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ



1. Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс хэрэгцээндээ тохирсон бөгөөд холбогдолтой тусламжийг хүлээн авна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь тохиромжтой бөгөөд холбогдолтой байна.



2. Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс хэрэгцээт хүмүүнлэгийн тусламжийг зөв зохистой цагтаа хүртэнэ.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь үр дүнтэй бөгөөд цагаа олсон байна.



3. Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үр дүн нь гамшигт өртсөн орон нутаг, хүмүүсийг бэлэн байдлаа илүү сайн хангасан, эрсдэлд бага өртөх, даван туулах чадвартай байхад чиглэх ба сөрөг үр нөлөөгүй байна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь орон нутгийн дотоод чадавхыг бэхжүүлж, сөрөг үр дагавраас зайлсхийнэ.



4. Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс нь эрхээ мэддэг, мэдээлэл авах боломжтой, мөн өөрсөддөө нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргахад оролцоотой байна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь харилцаа холбоо, оролцоо, санал зөвлөгөөнд тулгуурласан байна.



5. Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс санал хүсэлт гаргах, шийдвэрлэх, хянах аюулгүй бөгөөд шуурхай механизмаар хангагдсан байна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Гомдлыг хүлээн авч, шийдвэрлэнэ.



6. Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс нь зохион байгуулалттай, харилцан бие биенээ нөхсөн хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь зохион байгуулалттай бөгөөд нэмэлт байна.



7. Байгууллагууд туршлага, сургамжаасаа суралцах тусам тусламжийн үйл ажиллагаа улам сайжирна гэдэгт гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс итгэж болно.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн байгууллагууд тогтмол суралцаж, сайжирна.



8. Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс шаардлагатай тусламжийг чадвартай, удирдлага зохион байгуулалт сайтай ажилтнууд болон сайн дурынхнаар дамжуулан хүлээн авна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Ажилтнуудыг ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд тэдэнд шударга, адил тэгш хандана.



9. Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс нь тусламж үзүүлж буй байгууллагууд нөөцийг үр дүнтэй, үр ашигтай, ёс зүйтэй удирдан зохицуулж байгаа гэдэгт итгэж болно.

Чанарын шалгуур үзүүлэлт: Нөөцийг зориулалтын дагуу хариуцлагатай удирдан зохион байгуулж, ашиглана.



VII. АМЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

1 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс хэрэгцээндээ тохирсон бөгөөд холбогдолтой тусламжийг хүлээн авна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь тохиромжтой бөгөөд холбогдолтой байна.

Үндсэн үйл ажиллагаа

- 1.1 Орчин нөхцөл болон оролцогчдод системтэй, бодитой, байнгын дүн шинжилгээ хийнэ.
- 1.2 Хэрэгцээ⁵ болон эрсдлийг шударгаар үнэлж, харилцан адилгүй бүлгүүдийн⁶ өртөмтгий байдал болон чадавхыг ойлгосны үндсэн дээр тохиромжтой хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 1.3 Өөрчлөгдөж буй хэрэгцээ, чадавх, орчин нөхцөлд тохируулан хөтөлбөрүүдийг өөрчилнө.

Байгууллагын хүлээх үүрэг

- 1.4 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийн хэрэгцээ болон чадавхид үндэслэн алагчлахгүй, шударгаар тусламж үзүүлэх үүргийг бодлогоор дамжуулан хүлээнэ.
- 1.5 Нийгмийн бүлгүүдийн олон талт байдал, тэр дундаа эмзэг бүлгийн болон нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийг харгалзан үзсэн амлалтыг бодлогодоо тусгаж, бүрэлдэхүүн хэсгээр нь салгасан мэдээ баримтыг цуглуулна.
- 1.6 Нөхцөл байдалд тасралтгүй, зохистой дүн шинжилгээ хийх процессыг хэрэглэнэ.

⁵ “Хэрэгцээ шаардлага” гэдэгт тусламж, хамгаалал орно.

⁶ Үүнд жишээлбэл эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүд, залуус, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тодорхой цөөнх, эсвэл үндэсний цөөнх гэх мэт бүлгүүдийг тодорхой ялгаваргүйгээр хамруулж болно.



2 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс хэрэгцээтэй хүмүүнлэгийн тусламжийг зөв зохистой цагтаа хүртэнэ.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь үр дүнтэй бөгөөд цагаа олсон байна.

Үндсэн үйл ажиллагаа

- 2.1 Төлөвлөсөн үйл ажиллагаа нь бодитой бөгөөд орон нутгийнхны хувьд аюулгүй байх нөхцлийг хангах үүднээс аливаа саад бэрхшээлийг шийдвэрлэх хөтөлбөрийг төлөвлөнө.
- 2.2 Шийдвэр гаргах болон арга хэмжээ авах асуудлуудыг шалтгаангүйгээр хойшлуулалгүй, хүмүүнлэгийн хариу арга хэмжээг цаг тухайд нь хүргэнэ.
- 2.3 Хангагдаагүй хэрэгцээг холбогдох техникийн мэргэжлийн мэдлэгтэй, эрхтэй байгууллагад шилжүүлэх буюу эсвэл түүнийг шийдвэрлүүлэхэд нөлөө үзүүлнэ.
- 2.4 Хөтөлбөрүүдийг төлөвлөх болон үнэлэх ажиллагаанд хүмүүнлэгийн салбарт хэрэглэгддэг холбогдох техникийн Стандарт болон зохистой практикийг хэрэглэнэ.
- 2.5 Хөтөлбөрүүдийг тохиромжтой байдлаар өөрчлөх, гүйцэтгэл тааруу байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор хүмүүнлэгийн хариу арга хэмжээний үйл ажиллагаа, гарц, үр дүнг хянана.

Байгууллагын хүлээх үүрэг

- 2.6 Хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн амлалт нь байгууллагын хүчин чадалд нийцсэн байна.
- 2.7 Бодлогын хүрээнд хүлээсэн амлалт нь дараах боломжийг хангана. Үүнд:
 - а. Үйл ажиллагаанууд болон тэдгээрийн үр дүнг системтэй, бодитой, тасралтгүй хянана;
 - б. Хяналт, үнэлгээний баримтыг ашиглан хөтөлбөрт зохистой өөрчлөлт оруулж, сайжруулна;
 - в. Шийдвэрийг цаг алдалгүй гаргаж, нөөцийг зохистой хуваарилна.



3 Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үр дүн нь гамшигт өртсөн орон нутаг, хүмүүсийг бэлэн байдлаа илүү хангасан, эрсдэлд бага өртөх, даван туулах чадвартай байхад чиглэх ба сөрөг үр нөлөөгүй байна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь орон нутгийн дотоод чадавхыг бэхжүүлж, сөрөг үр дагавраас зайлсхийнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- 3.1 Хөтөлбөрүүд нь орон нутгийн чадавхыг хөгжүүлсэн бөгөөд гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийн даван туулах, тэсвэрлэх чадварыг сайжруулахад чиглэгдсэн байх явдлыг хангана.
- 3.2 Орон нутагт байгаа, өмнө нь хийгдсэн аюул, эрсдлийн үнэлгээ болон бэлэн байдлын төлөвлөгөөг үйл ажиллагаандаа удирдамж болгон ашиглана.
- 3.3 Ирээдүйд гамшиг тохиолдвол хамгийн түрүүн хариу арга хэмжээ авах этгээдийн хувиар орон нутгийн удирдлага болон орон нутгийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх боломжийг нээж, нийгмээс тусгаарлагдсан болон эмзэг бүлгийн хангамжийг зохистой хэмжээнд байлгана.
- 3.4 Хүмүүнлэгийн тусламжаас хамааралтай байх эрсдлийг бууруулахын тулд хүмүүнлэгийн хөтөлбөрийн эхний шатанд шилжих буюу гарах стратегийг төлөвлөж, урт хугацааны эерэг нөлөөг бий болгох явдлыг хангана.
- 3.5 Гамшгийн эрт үеийн сэргээн босгох үйл ажиллагааг дэмжиж, орон нутгийн эдийн засагт үр өгөөжөө өгөх хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 3.6 Доор дурьдсан болон бусад чиглэлээр гарч болзошгүй буюу урьд нь гарч байсан, урьдчилан тооцоолоогүй сөрөг үр нөлөөг цаг алдалгүй, системтэй тодорхойлж, түүний мөрөөр хариу арга хэмжээ авна. Үүнд:
 - а. хүмүүсийн аюулгүй байдал, хамгаалалт, нэр төр, эрх;
 - б. ажилтнуудын зүгээс ирэх бэлгийн дарамт, хүчирхийлэл;
 - в. ёс заншил, хүйс, нийгмийн болон улс төрийн харилцаа;
 - г. амьжиргаа;
 - д. орон нутгийн эдийн засаг;
 - е. хүрээлэн буй орчин

Байгууллагын хүлээх үүрэг

- 3.7 Бодлого, стратеги, удирдамж нь доор заасан зориулалттай байна. Үүнд:
 - а. ажилтнуудын зүгээс гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийг мөлжлөгөд ашиглах, хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах гэх мэт сөрөг үр дагаврууд гарахаас урьдчилан сэргийлнэ.
 - б. орон нутгийн дотоод чадавхыг бэхжүүлнэ.
- 3.8 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсээс цуглуулсан, тэднийг эрсдэлд оруулж болзошгүй хувийн мэдээллийг хамгаалах тогтолцоотой байна.



4 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс нь эрхээ мэддэг, мэдээлэл авах боломжтой, мөн өөрсөддөө нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргахад оролцоотой байна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь харилцан холбоо, оролцоо, санал зөвлөгөөнд тулгуурласан байна.

Үндсэн үйл ажиллагаа

- 4.1 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс нь байгууллагын тухай, байгууллагын баримталдаг зарчмуудын тухай, ажилтнуудын хэрхэн биеэ авч явах ёс зүйн хэм хэмжээ, байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд, хөтөлбөрүүдээр дамжуулан тэдэнд хүргэхийг зорьж буй зүйлсийн талаарх мэдээллээр хангагдана.
- 4.2 Тухайн орон нутаг, нийгмийн бүлэг, ялангуяа эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан бүлгүүдэд хялбархан ойлгогдох, хүндэтгэлтэй бөгөөд ёс заншил талаасаа тохиромжтой хэл, формат, мэдээллийн хэрэгслээр харилцана.
- 4.3 Ажлын үе шат болгонд гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийг оролцуулж, төлөөллийн оролцоог хангана.
- 4.4 Хүлээн авсан тусламжийн чанар, үр нөлөөнд хэр сэтгэл ханамжтай байгаа талаар гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгох бөгөөд санал бодлоо илэрхийлж буй хүмүүсийн хүйс, нас, олон талт байдлыг онцгой анхаарна.

Байгууллагын хүлээх үүрэг

- 4.5 Мэдээллийг харилцан бие биетэйгээ хуваалцах, илэн далангүй нээлттэй харилцах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлоготой байх.
- 4.6 Ажлын үе шат болгонд гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийг оролцуулж, тэдний тодорхойлсон нэн тэргүүний асуудлууд болон эрсдлүүдийг ажилдаа тусгах бодлоготой байна.
- 4.7 Хөрөнгө мөнгө босгох болон бусад зорилгоор явуулж буй гадаад харилцаа нь гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийг нэр төртэй хүн гэдэг үүднээс танилцуулсан үнэн зөв, ёс зүйтэй, хүндэтгэлтэй байна.



5 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс санал хүсэлт гаргах, шийдвэрлэх, хянах аюулгүй бөгөөд шуурхай механизмаар хангагдсан байна.

Чанарын шалгуур үзүүлэлт: гомдлыг хүлээн авч, шийдвэрлэнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- 5.1 Санал хүсэлт, гомдол хүлээн авах, шийдвэрлэх процессыг боловсруулах, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих асуудлаар гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүстэй зөвлөлдөнө.
- 5.2 Санал хүсэлт, гомдлыг нээлттэй хүлээн авч, энэ механизмыг ашиглах заавар болон механизмын хүрээнд шийдвэрлэх асуудлын цар хүрээний талаар мэдээлнэ.
- 5.3 Санал хүсэлт, гомдол гаргасан этгээдийн болон гамшигт өртсөн хүмүүсийн аюулгүй байдлын асуудлыг бүх шатанд нэн тэргүүнд тавьж, гомдлыг цаг алдалгүй, шударгаар, зохистой байдлаар шийдвэрлэнэ.

Байгууллагын хүлээх үүрэг

- 5.4 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсээс санал, гомдол хүлээн авч, шийдвэрлэх процесстэй байж, хүлээн авах, шийдвэрлэх үйл явцыг баримтжуулна. Энэ процесс нь бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, эрх мэдлийг зүй бусаар ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах талаар хөтөлбөрт тусгасан байна.
- 5.5 Санал хүсэлт, гомдлыг нухацтай авч үздэг, тодорхойлсон бодлого, процессын дагуу гомдлын мөрөөр арга хэмжээ авдаг байгууллагын соёл бүрэлдэж тогтсон байна.
- 5.6 Гамшигт өртсөн орон нутгийнхан болон хүмүүс хүмүүнлэгийн ажилтнуудын зохистой зан байдал болон бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх байгууллагын амлалтын талаар бүрэн дүүрэн мэдлэгтэй байна.
- 5.7 Байгууллагад хамаарахгүй гомдлыг зохистой практикийн дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ.



6 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс нь зохион байгуулалттай, харилцан бие биенээ нөхсөн хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь зохион байгуулалттай бөгөөд нэмэлт байна.

Үндсэн үйл ажиллагаа

- 6.1 Оролцогч талуудын үүрэг, хариуцлага, чадавх, ашиг сонирлыг тодорхойлно.⁷
- 6.2 Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь улсын болон орон нутгийн эрх барих байгууллагууд⁸, хүмүүнлэгийн бусад байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй давхардаагүй, харилцан бие биенээ нөхсөн байна.
- 6.3 Орон нутгийн хүсэлт шаардлагыг хянаж, өргөн хүрээний хүмүүнлэгийн хүчин чармайлтыг нэгтгэн, үзүүлэх тусламж, үйлчилгээний хангамжийг дээд зэргээр нэмэгдүүлэхийн тулд холбогдох зохицуулалтанд оролцож, бусад байгууллагуудтай хамтран ажиллана.
- 6.4 Харилцаа холбооны зохистой сувгийг ашиглан хамтрагч байгууллагууд, зохион байгуулах/зохицуулах бүлгүүд, үйл ажиллагаанд оролцож буй бусад холбоотой талуудтай шаардлагатай мэдээллийг хуваалцана.

Байгууллагын хүлээх үүрэг

- 6.5 Хүмүүнлэгийн зарчмуудыг алдагдуулахгүйгээр бусадтай, үүний дотор үндэсний болон орон нутгийн түвшний эрх бүхий байгууллагуудтай нягт уялдаатай хамтран ажиллах амлалт үүргийг тусгасан бодлого, стратегиудтай байна.
- 6.6 Хамтрагч байгууллагуудтай харилцан бие биенийхээ эрх, үүрэг, хараат бус бие даасан байдлыг хүндэтгэсэн, харгалзах хориг хязгаар, амлалт үүргийг хүлээн зөвшөөрсөн тодорхой бөгөөд нийцтэй гэрээний дагуу хамтран ажиллана.

⁷ Орон нутгийн үйл ажиллагаа явуулж буй хүмүүс, хүмүүнлэгийн байгууллагууд, орон нутгийн эрх бүхий байгууллагууд, хувийн компаниуд болон бусад холбоотой бүлгүүд багтана.

⁸ Эрх барих байгууллагууд мөргөлдөөний нэг тал бол хүмүүнлэгийн байгууллагууд үйл ажиллагааны хараат бус байдалтай жишиж өөрсдөө шийдвэр гаргах бөгөөд ийн шийдвэр гаргахдаа гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүсийн эрх ашгийг голлон анхаарна.



7 Байгууллагууд туршлага, сургамжаасаа суралцах тусам тусламжийн үйл ажиллагаа улам сайжирна гэдэгт гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс итгэж болно.

Чанарын шалгуур үзүүлэлт: Хүмүүнлэгийн байгууллагууд тогтмол суралцаж, сайжирна.

Үндсэн үйл ажиллагаа

- 7.1 Хөтөлбөрүүдийг боловсруулахдаа өмнөх сургамж болон туршлага дээрээ үндэслэн боловсруулна.
- 7.2 Хяналт, үнэлгээ, санал зөвлөгөө, гомдол зэргээс суралцахын зэрэгцээ тэдгээрт үндэслэн шинэчлэлт, өөрчлөлтийг хийж, хэрэгжүүлнэ.
- 7.3 Сурч мэдсэн зүйл болон шинэ санаачлагын тухай мэдээллийг дотооддоо, мөн гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс, бусад оролцогч талуудтай хуваалцана.
- 7.4 Байгууллагын хүлээх үүрэг
- 7.5 Үнэлгээ хийх болон сурч мэдэх бодлогуудтай байж, туршлагаасаа суралцан, практикаа сайжруулах арга хэрэгсэлтэй байна.
- 7.6 Мэдлэг, туршлагын талаар бүртгэл тэмдэглэл хөтөлж, байгууллагын хэмжээнд хүртээмжтэй ашиглах механизмтай байна.
- 7.7 Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний чиглэлээр ажил мэргэжил нэгтэй бусдаасаа болон салбарын хүрээнд суралцах, шинийг санаачлах үйлст байгууллага хувь нэмрээ оруулна.



8 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс шаардлагатай тусламжийг чадвартай, удирдлага зохион байгуулалт сайтай ажилтнууд болон сайн дурынхнаар дамжуулан хүлээн авна.

Чанарын шалгуур үзүүлэлт: Ажилтнуудыг⁹ ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд тэдэнд шударга, адил тэгш хандана.

Үндсэн үйл ажиллагаа

- 8.1 Ажилтнууд нь байгууллагын эрх хэмжээ, үнэт зүйлст нийцүүлэн зөвшилцөн тохиролцсон зорилт болон гүйцэтгэлийн стандартын дагуу ажил үүргээ гүйцэтгэнэ.
- 8.2 Ажилтнууд нь өөрт хамаарах бодлогуудыг дагаж мөрдөх бөгөөд тэдгээрийг дагаж мөрдөөгүйгээс үүдэн гарах үр дагаврыг ухамсарлан ойлгодог байна.
- 8.3 Ажилтнууд үүргээ гүйцэтгэхийн тулд шаардлагатай хувийн, техникийн болон менежментийн ур чадваруудыг хөгжүүлж, ашиглах бөгөөд үүнийг гүйцэлдүүлэхэд байгууллагын зүгээс хэрхэн дэмжлэг үзүүлж болохыг ойлгодог байна.

Байгууллагын хүлээх үүрэг

- 8.4 Байгууллага нь хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх удирдлагын болон хүний нөөцийн чадвар, чадавхитай байна.
- 8.5 Ажилтнуудын бодлого, журмууд нь шударга, ил тод, үл ялгаварлан гадуурхсан, орон нутгийн хөдөлмөрийн хуультай нийцсэн байна.
- 8.6 Ажилтнууд хүлээсэн үүрэг даалгаврынхаа талаар тодорхой ойлголттой байх үүднээс ажил үүргийн хуваарь болон ажлын байрны зорилт тодорхой байхын зэрэгцээ санал зөвлөгөө өгөх процесстэй байна.
- 8.7 Хүмүүсийг мөлжих, хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах үйлдэл гаргахгүй байхыг ажилтнуудад үүрэг болгосон ёсзүйн хэм хэмжээтэй байна.
- 8.8 Ажилтнуудыг мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийг дэмжсэн бодлоготой байна.
- 8.9 Ажилтнуудын аюулгүй байдал, сайн сайхныг хангах бодлоготой байна.

⁹ Ажилтнууд гэдэг нь: байгууллагын томилсон төлөөлөгч байх бөгөөд үүнд үндэсний, олон улсын, байнгын болон түр хугацааны ажилтнууд, сайн дурынхан, зөвлөхүүд орно.



9 Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс нь тусламж үзүүлж буй байгууллагууд нөөцийг үр дүнтэй, үр ашигтай, ёс зүйтэй удирдан зохицуулж байгаа гэдэгт итгэж болно.

Чанарын шалгуур үзүүлэлт: Нөөцийг зориулалтын дагуу хариуцлагатай удирдан зохион байгуулж, ашиглана.

Үндсэн үйл ажиллагаа

- 9.1 Чанар, зардал, цаг үеэ олсон байдал зэргийг тэнцүүлэн хариу арга хэмжээний үе шат бүрт нөөцийг¹⁰ үр ашигтай ашиглах явдлыг хангахуйц байдлаар хөтөлбөрийг боловсруулж, процессуудыг хэрэгжүүлнэ.
- 9.2 Нөөцийг зориулалтаар нь ашиглаж, зохистой удирдан, үргүй зардлыг багасгана.
- 9.3 Зарцуулалтыг төсвийн дагуу хянаж, тайлагнана.
- 9.4 Орон нутгийн нөөц болон байгалийн баялаг ашиглахдаа байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзнэ.
- 9.5 Авлигын эрсдлийг удирдан зохицуулж, илрүүлсэн тохиолдолд зохистой арга хэмжээг авна.

Байгууллагын хүлээх үүрэг

- 9.6 Нөөцийн ашиглалт, удирдлагыг зохицуулсан бодлого, процесстой байна. Үүнд:
 - А. Хөрөнгө мөнгө болон тусламжийн бараа үйлчилгээг байгууллага хэрхэн ёс зүйтэй бөгөөд хууль ёсны байдлаар хүлээн авч, хуваарилах тухай;
 - Б. Байгууллага нөөцийг хэрхэн байгаль орчны талаасаа хариуцлагатай байдлаар ашиглах тухай;
 - В. Байгууллага авлига, залилан, ашиг сонирхлын зөрчил, нөөцийн зохисгүй ашиглалт зэргээс хэрхэн урьдчилан сэргийлж, эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай;
 - Г. Байгууллага хэрхэн аудитыг гүйцэтгэж, хэрэгжилтийг нягтлан шалгаж, ил тод мэдээлэх тухай;
 - Д. Байгууллага эрсдлийг хэрхэн тогтмол үнэлж, удирдан, бууруулах тухай;
 - Е. Нөөцийг хүлээн авснаар байгууллагын хараат бус, бие даасан байдал алдагдахгүй гэдгийг хэрхэн баталгаажуулах тухай.

¹⁰ “Нөөц” гэдэг нэр томъёог өргөн утгаар нь ойлгож, эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд байгууллагад шаардагдаж буй хөрөнгө мөнгө, хүн хүч, бараа материал, тоног төхөөрөмж, цаг хугацаа, газар, хөрс, ус, агаар, байгалийн бүтээгдэхүүнүүд, байгаль орчин зэргийг ерөнхийд нь хамруулж үзнэ.

VIII. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

CHS-д хэрэглэсэн дараах нэр томъёо, үг хэллэг нь доор тодорхойлсон утгатай байна. Үүнд:

Хариуцлагатай байдал: эрх мэдлийг хариуцлагатай ашиглаж, өөр өөр харилцан адилгүй оролцогчдын өмнө, ялангуяа тухайн эрх мэдлийн хэрэгжилтийн нөлөөнд өртсөн хүмүүсийн өмнө хариуцлага хүлээх процесс

Гамшигт өртсөн орон нутаг болон хүмүүс: өөр өөр хэрэгцээ, шаардлагатай, эмзэг байдал, чадавхын хувьд харилцан адилгүй бөгөөд тодорхой нэг байршилд гамшиг, мөргөлдөөн, ядуурал болон бусад хямралт нөхцөл байдалд өртсөн нийт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийг хэлнэ.

Баримт бичиг: хэлэлцүүлэг, тохиролцоо, шийдвэр болон/буюу үйл ажиллагаанд холбогдох бөгөөд хуулбарлах боломжтой аливаа хэлбэрийн тэмдэглэл.

Үр дүнтэй байдал: тусламжийн үйл ажиллагаа өөрийн зорилтуудаа ханган биелүүлж буй түвшин/хэмжээ.

Үр ашигтай байдал: тодорхой хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны үр дүнд хүмүүнлэгийн хөтөлбөрийн үр дүн нь тоон болон чанарын аль ч үзүүлэлтээрээ хангагдаж буй байдал.

Татан оролцуулах: байгууллагууд сонирхсон ба/буюу өртсөн оролцогч талуудтай харилцаж, зөвлөлдөн, тэдний оролцоог хангаж, тусламж үзүүлэх хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон эргэн хянах үедээ тэдний сэтгэлийг чилээсэн асуудлууд, хүсэлт, хүлээлт, хэрэгцээ, эрх болон боломжийг харгалзан үзэж буй процесс.

Хүмүүнлэгийн арга хэмжээ: хүний үйл ажиллагаанаас үүдсэн, эсвэл байгалийн гамшгийн үеэр болон түүний дараа хүний амь насыг аврах, зовлон шаналалыг багасгах, хүний нэр төрийг хамгаалах зорилготой арга хэмжээ, мөн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээ¹¹.

Байгууллага: CHS-ыг хэрэглэх удирдлагын бүтэц болон эрх мэдэл бүхий аж ахуйн нэгж.

Хамтрагч байгууллага: тодорхой нэг зорилгод хүрэхээр албан ёсны зохицуулалттайгаар хамтран ажиллаж буй, үүрэг, хариуцлага нь тодорхой байгууллагууд.

Бодлого: зорилго болон шийдвэр гаргах тухай дүрмийн баримтжуулсан тодорхойлолт/мэдэгдэл.

Хамгаалалт: нас, хүйс, үндэс угсаа, нийгмийн, шашны болон бусад статусыг харгалзахгүйгээр хувь хүн нэг бүрийн эрхийг бүрэн, тэгш хангахад чиглэсэн бүх үйл ажиллагаа. Энэ нь онцгой байдлын үед голлон анхаардаг ажил болох амь нас аврах шууд үйл ажиллагаанаас илүү өргөн хүрээний ойлголт.

Чанар: тусламж үзүүлэхээр зорьж буй хүмүүсийн нэр төрийг хүндлэх, тэдний дурьдсан буюу эсвэл тухайн нөхцөл байдлаас урган гарсан хэрэгцээ хийгээд хүлээлтийг цаг хугацаанд нь амжиж хангах чадварыг баталсан хүмүүнлэгийн тусламжийн өвөрмөц онцлог болон шинж чанарын нэгдэл.

Даван туулах, чадвар: аюулын нөлөөг цаг хугацаанд нь үр дүнтэйгээр ойлгох, даван туулах, дасан зохицох, нөхөн сэргээхэд чиглэсэн орон нутаг болон олон нийт, байгууллага, нийгмийн чадавхи

Ажилтан: аливаа байгууллагын нэрлэсэн төлөөлөгч бөгөөд үүнд үндэсний, олон улсын, байнгын болон түр хугацааны ажилтнууд, сайн дурын ажилтнууд болон зөвлөхүүд орно.

11

ALNAP үнэлгээ Хүмүүнлэгийн арга хэмжээний туршилтын удирдамжид тодорхойлсноор. 2003 он. Хуудас 14.

Чанар, хариуцлагатай байдлын Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (CHS)-д хүмүүнлэгийн хариу арга хэмжээнд оролцож буй байгууллагууд болон хувь хүмүүс өөрийн үзүүлж буй тусламжийн чанар, үр нөлөөг сайжруулах зорилгоор хэрэглэж болох Есөн амлалт үүргийг тусгасан. Мөн уг Стандарт нь хүмүүнлэгийн байгууллагуудыг гамшигт өртсөн орон нутаг болон хувь хүмүүсийн өмнө илүү хариуцлагатай ажиллах нөхцлийг бүрдүүлжээ. Өөрөөр хэлбэл хүмүүнлэгийн байгууллагуудын хүлээсэн үүргийг гамшигт өртсөн орон нутаг болон хувь хүмүүс мэдэж авснаар тухайн байгууллагуудтай хариуцлага тооцох боломжийг тэдэнд бүрдүүлж өгсөн байна.

Үндсэн Стандарт болохынхоо хувьд CHS нь зарчимч, хариуцлагатай, чанартай хүмүүнлэгийн арга хэмжээний үндсэн элементүүдийг тодорхойлж өгсөн байна. Хүмүүнлэгийн байгууллагууд өөрийн дотоод журмуудыг нийцүүлэх сайн дурын хууль болгон энэхүү стандартыг хэрэглэж болно. Мөн ажлын гүйцэтгэлийг шалгах үндэс суурь болгон уг стандартыг хэрэглэж болно.

CHS нь NAP International, People In Aid, Sphere Project нарын зүгээс 12 сарын хугацаанд зохион байгуулсан, гурван үе шат бүхий зөвлөгөөний үр дүн бөгөөд энэ хугацаанд хэдэн зуун хувь хүмүүс болон байгууллагууд CHS-ын агуулгыг сайтар шинжилж, дээрх байгууллагуудын төв байр болон ажлын талбарын түвшинд шалгаж туршсан болно.

 [corehumanitarianstandard](https://www.facebook.com/corehumanitarianstandard)

 [@corehumstandard](https://twitter.com/corehumstandard)

www.corehumanitarianstandard.org | info@corehumanitarianstandard.org

ISBN: 978-2-8399-1564-9

